



ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 06 сарын 14 өдөр

Дугаар А/326

Эрдэнэт

Төлөвлөгөө батлах тухай


Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай” хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5/д/, 29.2, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 22.1.2, 23 дугаар зүйл, Монгол улсын Засгийн газрын 2011 оны 375 дугаар тогтоол, Орхон аймгийн ИТХ-ын 2017 оны 5/02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Эрдэнэтчүүд Эрдэнэтчүүддээ хайртай” /Нэг өрх-Нэг ажлын байр/ дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг нэгдүгээр, зохион байгуулах ажлын хэсгийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2017 оны зардалд шаардагдах 40000000 /Дөчин сая/ төгрөгийг аймгийн Засаг даргын 2017 оны 6 дугаар сарын 5-ны “Хуваарилалт хийх тухай” А/306 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Эрдэнэтчүүд Эрдэнэтчүүддээ хайртай дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2017 оны арга хэмжээ, санхүүжилт”-ээс гаргаж Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд санд хуваарилахыг Санхүү төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

3.Дэд хөтөлбөрийг хэрэгжилтийг хангаж ажиллах, төсвийг хуваарийн дагуу зарцуулж ажиллахыг Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар /н.Эрдэнэбат/-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.БАТЛУТ